

МАЛЫН УДМЫН САН, ЭРҮҮЛ МЭНДИЙГ ХАМГААЛАХ ТУХАЙ

/ шинэчилсэн найруулга/

Хуулийн нэр	Хуулийн зорилго	Худалдаатай холбоотой заалтууд
Малын удмын сан, эрүүл мэндийг хамгаалах тухай / шинэчилсэн найруулга/	Энэ хуулийн зорилт нь мал, тэжээвэр амьтны /цаашид “мал” гэх/ удмын сан, эрүүл мэндийг хамгаалахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.	14 дүгээр зүйл. Иргэн, хуулийн этгээдийн үүрэг 14.1. Иргэн, хуулийн этгээд дараахь нийтлэг үүрэг хүлээнэ: 14.1.1. малыг нядлах, малын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүн, малын тэжээл бэлтгэх, боловсруулах ажлыг ариун цэвэр, эрүүл ахуйн шаардлага хангасан байр, агуулах, орчинд хийж гүйцэтгэх; 14.1.2. мал, малын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүн, малын тэжээлийг аймаг, нийслэл, сумын нутаг дэвсгэрээс нөгөөд шилжүүлэх, нийтийн хэрэгцээнд нийлүүлэх, тээвэрлэх, хүлээн авах, улсын хилээр нэвтрүүлэхэд мал эмнэлэг, ариун цэврийн үзлэг, шинжилгээ хийлгэж гэрчилгээ авах;